

БАТЛАВ:

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  Д. МӨНХБААТАР

**ЗУУНМОД СУМЫН НАЦАГДОРЖ 5-Р БАГИЙН ГЭР ХОРООЛЛЫН ТӨВЛӨРСӨН  
ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ  
БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

Дугаар 01/24

2024 оны 02 сарын 23-ны өдөр

Зуунмод хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Төв аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр “Хөгжлийн түүчээ” Төв аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Зорилго: Зуунмод сумын 5-р багийн гэр хорооллын сууршлын хэсгийн айл өрхийг инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээнд холбон амьдрах орчин нөхцлийг сайжруулах
2	Байршил, инженерийн шугам сүлжээний одоогийн байдал	Байршил: Төв аймгийн Зуунмод сум, 5-р баг, гэр хорооллын сууршлын хэсэг Хүн ам: Зуунмод сум нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 17264 Хүн ам, 4968 өрхтэй. Үүнээс 5-р баг нь 3155 хүн ам, 921 айл өрхтэй. Тус багийн төсөл хэрэгжих гэр хорооллын сууршлын бүсэд 148 айл өрх амьдарч байна. Одоогийн байдал: Зуунмод сум нь Нийслэл Улаанбаатар хотоос 42 км зайд оршдог ба 6 багт хуваагддаг. Зуунмод хот нь Төвийн бүсийн тулгуур төв хот бөгөөд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь Засгийн газрын 2019 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан. Нацагдорж баг нь 246,4 га газар нутагтай. Багийн төвийн байр-1, Дэлгүүр, үйлчилгээ-3 үйл ажиллагаа явуулж байна. Цахилгаан хангамж: Цахилгаан хангамжийн нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон. 10/0,4кВ-ын 250кВа –ын 2ш дэд станцтай. Усан хангамж: Зөөврийн ус түгээх байр 2ш, 1033 м цэвэр ус дамжуулах шугам сүлжээтэй. Ариутгах татуурга: Төвлөрсөн ариутгах татуургын системгүй. Хойд талын 3 гудамжинд ариутгах татуургын 697м шугам сүлжээ, 25м <sup>3</sup> /хон хүчин чадалтай септик цэвэрлэх байгууламж 2011 онд байгуулсан боловч ашиглалтгүй байгаа. Дулаан хангамж: Нэгдсэн дулаан хангамжийн систем байхгүй. Орон сууцны хангамж: Байхгүй. Холбоожуулалт: Холбоожуулалтын нэгдсэн сүлжээ байгуулагдсан.
3	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ	Нацагдорж багийн гэр хорооллын одоогийн сууршлын 30 га, талбайг хамруулан төлөвлөнө.
4	Зураг төсөл боловсруулах ажлын үе шат	<u>Нэгдүгээр үе шат:</u> - Байр зүйн болон дэвсгэр зураг; - Инженер геологийн судалгаа хийж, дүгнэлт гаргах - Одоогийн шугам сүлжээний эх үүсвэр, шугам сүлжээний судалгаа хийх - Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг судлах тусгах - Нийтийн халуун усны нэг маягийн ажлын зураг төсөл



		<p>боловсруулах</p> <p><u>Хоёрдугаар үе шат: Ажлын зураг төсөл боловсруулах</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дулаан хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, хэрэглээний халуун усны шугам сүлжээ</li> <li>- Усан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг</li> <li>- Ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг</li> <li>- Цахилгаан хангамжийн 10/0,4кВ-ын 160кВа хүчин чадалтай КТПН, шугам сүлжээ /шинээр байгуулагдахаар төлөвлөж буй УДТТ, насос станц/</li> <li>- Холбооны шилэн кабель, сервер /Нийтийн халуун усны газарт/</li> <li>- Нийтийн халуун усны барилга зураг төсөл /нэг маягийн/</li> </ul>
5	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Монгол Улсын хуулиуд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль;</li> <li>- Барилгын тухай хууль;</li> <li>- Хот суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль;</li> <li>- Эрчим хүчний тухай хууль;</li> <li>- Бусад хууль тогтоомж;</li> </ul> <p><u>Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг “Алсын хараа 2050”;</li> <li>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;</li> <li>- Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө</li> <li>- Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр</li> <li>- Бусад.</li> </ul> <p><u>Норм норматив, стандарт:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-04);</li> <li>- “Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам” БНБД 33-01-03 (ДБС-ын 2003 оны 134 дүгээр тушаал);</li> <li>- “Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж” БНБД 40-01-14 (БХБ-ын сайдын 2014 оны 90 дүгээр тушаал);</li> <li>- “Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж” БНБД 40-02-16 (БХБ-ын сайдын 2016 оны 116 дугаар тушаал);</li> <li>- “Дулааны сүлжээ” БНБД 41-02-13 (БХБ-ын сайдын 2014 оны 136 дугаар тушаал);</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм, заавар, стандарт</li> </ul>
6	Баримт бичгийн бүрдэл	<p><u>Сүүрх судалгаа:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байр зүйн зураг М1:1000</li> <li>- Инженер-геологийн судалгааны дүгнэлт</li> <li>- Ерөнхий төлөвлөлтийн хүрээнд эрэлт хэрэгцээ, эх үүсвэр, хангамж, хүчин чадлын судалгаа, өнөөгийн байдлын үнэлгээ.</li> </ul> <p><u>Зураглалын материал:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Инженерийн шугам сүлжээний нэгдсэн зураг М1:1000</li> <li>- Дулаан хангамж /Ус дулаан дамжуулах төвийн барилга, шугам сүлжээ М1:1000</li> <li>- Ус хангамжийн шугам сүлжээ М1:1000</li> <li>- Ариутгах татуургын шугам сүлжээ, насос станц М1:1000</li> <li>- Цахилгаан хангамж /эх үүсвэр, шугам сүлжээ М1:1000</li> <li>- Хэрэглээний халуун усны шугам сүлжээ <u>М1:1000</u></li> <li>- Холбоожуулалт М1:1000</li> </ul>



		<p>- <u>Инженерийн бэлтгэл арга хэмжээ M1:1000</u>  <u>Ажлын зураг:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дулаан хангамжийн эх үүсвэр УДДТ</li> <li>- Дулаан хангамжийн шугам сүлжээ 1 –р хэлхээ</li> <li>- Дулаан хангамжийн шугам сүлжээ 2 –р хэлхээ</li> <li>- Хэрэглээний халуун усны шугам сүлжээ</li> <li>- Цэвэр усан хангамжийн шугам сүлжээ</li> <li>- Ариутгах татуургын шугам сүлжээ, насос станц</li> <li>- 25м3/хон цэвэрлэх байгууламжийн засварын ажлын зураг төсөл</li> <li>- Цахилгаан хангамжийн 10/0,4кВ-ын 1x160Ква хүчин чадалтай КТПН</li> <li>- Холбооны шугам сүлжээ, шилэн кабель, серверийн ажлын зураг</li> <li>- Магадалын дүгнэлт /ерөнхий болон хавсралт/</li> <li>- Батлагдсан (зураг төсөл, тайлбар бичиг)-г хэвлэмэл болон файл байдлаар (CD-нд бичиж) 4 хувь бэлтгэж, захиалагчид эх хувь 1, хуулбар 3 хувийг хүлээлгэж өгнө.</li> </ul>
7	Шийдвэрлэх үндсэн асуудлууд	<ul style="list-style-type: none"> <li>- Дулаан хангамжийн нэгдсэн эх үүсвэрийг одоо байгаа 7 дугаар зуухнаас хангахаар төлөвлөнө.</li> <li>- 1-р хэлхээний 520м шугам сүлжээнээс Ус дулаан дамжуулах төв төлөвлөнө.</li> <li>+ 1 –р хэлхээний шугам огтлолцох хэсэгт гол таарч байгаа тул гол дээгүүр агаарын шугам төлөвлөх ✓</li> <li>- УДДТөөвөөс айл өрхүүдийн хэрэглэгчийн 2072м 5 хос /Дулаан хангамж, цэвэр усан хангамж, хэрэглээний халуун ус/ шугам төлөвлөх</li> <li>- Гудамжинд байгуулагдах салбар шугамаас айл өрхүүдийг хамгийн ойр холбогдохоор зураг төсөл боловсруулна.</li> <li>- Инженерийн дэд бүтцийн эх үүсвэр, хүчин чадлыг эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэй, оновчтой цогц байдлаар төлөвлөх:</li> <li>- Ариутгах татуургын шугам сүлжээг төвлөрсөн шугам сүлжээнд холбох, шаардлагатай тохиолдолд бохир усны өргөх насос станц төлөвлөх</li> <li>- Зураг төслийг боловсруулахдаа “Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдгийн стандарт” MNS 6736:2018-ыг баримтлан Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн ХБК-ын мэдээллийн сангийн суурь нөхцлийг бүрдүүлэх.</li> </ul>
8	Инженерийн байгууламж, шугам сүлжээний эх үүсвэр, хангамж	<p>Инженерийн шугам сүлжээг дулаан хангамж, цэвэр усан хангамж, хэрэглээний халуун усны 5 хос шугам төлөвлөнө.</p> <p><u>Дулаан хангамж:</u>  Одоо байгаа 7-р халаалтын хэсгээс дулаан хангамжийн 1-р хэлхээний шугам огтлол авч, УДДТөв байгуулан холбох ба шинээр байгуулагдах дулааны станцын УДДТөвтэй холбохоор тооцож төлөвлөх</p> <p><u>Усан хангамж:</u>  Ус хангамжийн эх үүсвэрийг 7-р халаалтын хэсгээс төвлөрсөн эх үүсвэрээс холбон шинээр байгуулах ус дулаан дамжуулах төвөөс түгээхээр тооцох</p> <p><u>Ариутгах татуурга:</u>  Одоо байгаа 25м3/хон цэвэрлэх байгууламжийг засварлан эхний ээлжийн хэрэглээг хангах, цаашид Зуунмод хотын төв ариутгах татуургын сүлжээнд 2000 м шугам сүлжээг байгуулан холбож</p>



		зайлуулахаар төлөвлөнө. <u>Холбоожуулалт:</u> Ус дулаан дамжуулах шилэн кабень татан сервер байгуулах <u>Цахилгаан хангамж:</u> Дулаан хангамжийн эх үүсвэрийн орчим 1 байршилд 10/0,4кВ-ын 160кВА-ын КТПН байгуулахаар төлөвлөх
9	Эдийн засгийн тооцоо, төсөв	Зураг төсөлд тусгагдсан шугам сүлжээний ажилбар тус бүрээр ажлын төсөв боловсруулах ба нэгдсэн төсвийн нэгтгэл хүснэгтээр нийт хөрөнгө оруулалтын ажлыг нэгтгэж төсөвлөнө. Төсвийг эстиматор про 21 программаар хийсэн байна.
10	Төслийн онцгой нөхцөл	Аж ахуйн нэгж, үйлчилгээ, айл өрхүүдийг инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбохоор төлөвлөх
11	Зураг төсөл боловсруулах хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 6 сар /Магадлалын дүгнэлт гарч батлуулах хугацаа орсон./
12	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Орон нутгийн хөрөнгө оруулалт, Зураг төсөл боловсруулах үнэд геодези, инженер геологийн судалгаа, зураг төсөл боловсруулах, магадлалаар хянуулан батлуулах, зөвшөөрөлцөх зардал, НӨАТ зэрэг бүх зардлыг оруулан тооцно.
13	Захиалагч байгууллага	Төв Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
15	Гүйцэтгэгч байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна.
16	Зөвшөөрөлцөх байгууллага	Төв аймгийн ЗДТГ, Зуунмод сумын ЗДТГ, ГХБХБГазар, аймгийн ерөнхий архитектор болон хангагч байгууллагатай зөвшөөрөлцөх; Хангагч байгууллагууд болох МХС ХХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК-с техникийн нөхцөл авч, зураг төсөл зөвшөөрөлцөх Ажлын зураг төслийн баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах;

**ЗӨВШӨӨРӨЛЦСӨН:**

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга  
**ХЯНАСАН:**

Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга  
Зуунмод сумын Засаг дарга

**БОЛОВСРУУЛСАН:**

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын захиалагч инженер

Д.Саран-Эрдэнэ

Б.Насанжаргал

Ц.Сарангэрэл

Д.Алтансүх

Ц.Нямгарав